

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Компанийн бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орсон.

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023 оны 03 дугаар сарын 17-ны өдөр

Байгууллагын нэр:

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК

Нэгжийн нэр:

Дамжуулах сүлжээ ашиглалтын газар, Налайх төв

Албан тушаалын нэр:

Техникч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Техникч

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Худаг сувгийн байгууламж болон кабель шугамын байгууламжийн өдөр тутмын техникийн ашиглалтыг бүрэн хариуцаж тогтвортой ажиллагааг хангаж ажиллах.

Албан тушаалын зорилт:

1. Худаг сувгийн байгууламж болон кабель шугамын байгууламжийн өдөр тутмын хэвийн ажиллагааг хянаж ажиллах;
2. Кросст хөтлөгдөх анхан шатны бүртгэл маягтыг хөтлөх, гэмтлийн судалгааг хийх;
3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдох хууль, дүрэм журмыг мөрдөн ажиллах;
4. Удирдлагыг мэдээллээр хангах, ажлаа тайлагнах, танилцуулах, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг
1 дүгээр зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none">1. Компанийн үндсэн сүлжээний тоног төхөөрөмжийн цахилгаан хангамжийн тасралтгүй ажиллагааг хангаж тэжээлийн болон шилэн кабелийн урьдчилан сэргийлэх үзлэг үйлчилгээ их болон засвар хэмжилт тохируулгын ажлыг төлөвлөгөөтэйгөөр технологийн дагуу чанартай найдвартай хийн ажиллах нөхцөлийг хангах. Техникийн бэлэн байдлын түвшин, тусгаарлалтын эсэргүүцлийг харгалзан хийх ажлыг төлөвлөн засвар үйлчилгээ хийхэд хяналт тавин ажиллах;2. Хариуцсан кабель шугамын байгууламжинд гарсан гэмтэл саатлыг хяналтын хугацаанд нь үлдэгдэл, гологдолгүй засварлуулж, хайгуул, шинэ тавилтыг хяналтын хугацаанд нь гологдолгүй гүйцэтгүүлэх.

<p>2 дугаар зорилтын хүрээнд</p>	<ol style="list-style-type: none"> 1. Кроссын байгууламжинд засварын ажлын бэлтгэлийг бүрэн хангаж ажиллах; 2. Өдөрт хийсэн ажлыг бүртгэн мэдээ тайланг нэгтгэн техник үйлчилгээний тасагт өгөх, кабельчдын нарядын бүртгэлд хяналт тавьж ажиллах; 3. 1 цаг тутамд кабельчидтай харьцаж гэмтэл саатлыг цаг алдалгүй засварлуулж ажиллах; 4. Хариуцсан тасгийн хүрээнд кабелийн байгууламжийн анхан шатны бүртгэл маягтыг хөтлөх; 5. Гэмтэл саатлын судалгааг нарийвчлан гаргаж, түүнд анализ хийж дахин гаргуулахгүй байх талаар саналаа өгч ажиллах; 6. Аливаа гэмтэл саатлыг засварлахдаа технологийг мөрдлөг болгон ажиллах; 7. Олон нийтийн ажилд идэвхтэй оролцох, цаг үеийн шаардлага гарсан ажилд шуурхай оролцож ажиллах; 8. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивт баримт шилжүүлэх; 9. Фейс программд худаг сувагчлал, кабель шугамын мэдээллийг шинэчлэн боловсруулж оруулах; 10. Фейс программд өдөр бүрийн 15 цагт хийгдсэн ажил, аутсоурингийн түлш хүргэлт, захиалгат ажлуудын талаарх мэдээллийг үнэн зөв оруулах; 11. Бараа материалын үлдэгдэл шалгаж шаардлагатай материалыг захиалах; 12. ХАБЭА-н хувцас хэрэгслийг тухай бүрт нь захиалах, хүлээж авах, хүлээлгэн өгөх.
<p>3 дугаар зорилтын хүрээнд</p>	<ol style="list-style-type: none"> 1. Компанийн дотоод журам хөдөлмөрийн сахилга бат, хөдөлмөрийн аюулгүй, эрүүл ахуйн дүрэм, улсын хяналтын дүрэм, харилцаа холбооны хууль, түүнд заагдсан технологийн дүрмийг баримталж ажиллах; 2. Гэмтэл сааталд явахдаа ХАБЭА-н зааварчилгааг ашиглалтын менежерээс авна. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг мөрдөж ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу тогтмол хэрэглэж осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх; 3. Ажилтан нь ХАБЭА-н шаардлага, стандарт, дүрэм, технологийн горимыг чанад мөрдөх; 4. Ажилтан нь өөрийн ажлын байрандаа ХАБЭА-н аюулгүй байдлыг хангаж ажиллах; 5. Ажилтан, ажил олгогчийн хамтын ажиллагааны үндсэн дээр эрсдлийг бууруулж аюулыг арилгах нөхцөлийг тасралтгүй сайжруулах; 6. ХАБЭА-н сургалтанд хамрагдаж, шалгалт өгч, аюулгүй ажиллагааны зааварчилга авсан байх; 7. Эрүүл мэндээ хамгаалах, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд орох; 8. Ажлын тусгай хувцас хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэх; 9. Ажил үүргээ осол эндэгдэлгүй гүйцэтгэх арга барил, мэргэжлийн ур чадвар эзэмших, осол гэмтэл, хурц хордлогоос сэргийлэх, болзошгүй аюул, ослын үед анхны тусламж үзүүлэх чадвар эзэмшсэн байх; 10. Ажил олгогчийн зүгээс хууль тогтоомжийн хүрээнд нийцүүлэн тавьсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг биелүүлж ажиллах; 11. MNS 5596:2020 стандартад заасны дагуу ажилтан нь өөрийн ажлын байранд хамаарах аюулгүй ажиллагааны зэрэглэлийн шаардлага, мэдвэл зохих ур чадвар дадалтай байх; 12. Ажилтан нь ажил эхлэхийн өмнө ажлын байрандаа ажиглалт хийж, аюул эрсдэлтэй зүйл байгаа эсэхийг ажиглан, эрсдэл аюулыг арилгах буюу өөрөө арилгаж чадахааргүй бол удирдлагадаа мэдэгдэн арилгуулах арга хэмжээ авах, бусдад болзошгүй аюулыг сэрэмжлүүлэх; 13. Ажилтан нь ажлын байранд болон ажил гүйцэтгэх явцад илрүүлсэн аливаа аюул эрсдлийг аюулыг мэдээлэх хуудсаар бичиж мэдээлэх; 14. Ажилтан нь галын аюулгүй байдлыг хангаж ажиллах ба компаниас зохион байгуулж буй гал түймрээс урьдчилан сэргийлэх, гал түймрийг унтраах, аврах, нүүлгэн шилжүүлэх, анхны тусламж үзүүлэх мэдлэг чадвар олгох

	сургалтанд зайлшгүй хамрагдах, дадлагажих; 15. Өөрийн хариуцсан ажлын хүрээнд компанийн ХАБЭА-н дүрэм, Галын аюулын байдлын дүрмийн хэрэгжилтийг хангуулах, ХАБЭА-н гурван шатны хяналтыг хийх (I шат).
4 дүгээр зорилтын хүрээнд	1. Удирдлагыг газрын чиг үүрэгт хамаарах асуудлын хүрээнд мэдээллээр хангах, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх; 2. Удирдлагад ажлаа тайлагнах, танилцуулах; 3. Шаардлагатай үед ажлын байран дээр дуудагдаж ажиллана. Зайлшгүй тохиолдолд ажлын байранд сэлгэн ажиллах ба тухайн ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажил үүргийг гүйцэтгэнэ.
III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА	
Боловсрол	Тусгай дунд, бүрэн дунд боловсролтой байх.
Мэргэжил	Мэдээлэл, харилцаа холбооны технологиуд, инженер /061/.
Мэргэшил	Мэргэшлийн сургалтад хамрагдсан бол давуу тал болно.
Туршлага	Мэргэжлийн салбартаа 2-оос доошгүй жил ажилласан.
Ур чадвар	Харилцааны өндөр мэдлэгтэй, эерэг хандлагатай, худаг сувгийн байгууламж, кабель шугамын техник ашиглалт, ажилд мөрдөгдөх бүх технологи, зааварчлага, хууль тогтоол тушаал шийдвэрийг сайн мэддэг.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ	
Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Ашиглалтын менежер	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект: 1. Компанийн нийт ажилтнууд 2. Холбогдох бусад байгууллага, иргэн хуулийн этгээд
V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
БОЛОВСРУУЛСАН:	БАТАЛСАН:
<p>ДАМЖУУЛАХ СҮЛЖЭЭ АШИГЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА</p> <p></p> <p>А.ДАМДИН</p> <p>2023 оны 03-р сарын 17-ны өдөр</p>	<p>ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ</p> <p>(тамга/тэмдэг)</p> <p></p> <p>Д.МЯНГАНБААТАР</p> <p>2023 оны 03-р сарын 17-ны өдөр</p>